



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 03 өдөр

Дугаар 6/50

Хэрлэн сум

Шагнаж урамшуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1, 60.1.21, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.16, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Аймгийн 2021 оны төсөв батлах тухай” 2020 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Боловсролын салбарын 101 жилийн ойг тохиолдуулан Монголын багш нарын 56 дахь өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд масс сургалтын чанарыг амжилттай ахиулсан багш, сургалтын байгууллага, мэргэжлийн бүлгийг тус тус шагнаж урамшуулсугай.

2.Шагнагдах багш, байгууллагын нэрсийг хавсралтаар баталсугай.

3.Шагналд шаардагдах 10,000,000 (арван сая) төгрөгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Чадварлаг багш, чанартай боловсрол” зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Өнөрцэцэг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2022
онь... дүгээр сарын...-ны
... дугаар захирамжийн хавсралт

МОНГОЛЫН БАГШ НАРЫН 56 ДАХЬ ӨДРИЙН
БАЯРЫН ШАГНАЛЫН ЗАРДАЛ

№	Шагналын төрөл	Тоо	Мөнгөн шагнал (/ мян.төг)	Нийт шагнал / мян.төг/
1	Мэргэжлийн хөгжлийн бүлэг	2	500.00	1.000.00
2	Сургалтын менежерүүд	3	500.00	1.500.00
3	Анги удирдсан багш	4 /АУБ/	100.00	400.00
		4 / Бага анги/	50.00	200.00
4	Хичээл заасан багш	10	100.00	1.000.00
5	800 оноо	6	100.00	600.00
7	Шилдэг сургууль	1 байр	1.000.00	1.000.00
		2 байр	800.00	800.00
		3 байр	500.00	500.00
8	Шилдэг цэцэрлэг	1 байр	800.00	800.00
		2 байр	700.00	700.00
		3 байр	600.00	600.00
		4 байр	500.00	500.00
		5 байр	400.00	400.00
НИЙТ				10,000.00